


БАТЛАВ  
БСШУСЯ-НЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА  
.....Т.НЯМ-ОЧИР



БАТЛАВ  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДЭД ДАРГА  
ХУРАНДАА.....В.УУГАНБАЯР



БАТЛАВ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА  
.....М.ЭНХ-АМАР



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН “ӨСВӨРИЙН АВРАГЧ”  
БҮЛГИЙН АЖИЛЛАХ ЗААВАР /үлгэрчилсэн дүрэм/

2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Өсвөрийн аврагч бүлэг” нь өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд, сурагчдын сайн дурын үндсэн дээр байгуулагдана. Бүлгийн гишүүд нь сурагчдыг болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, осол, гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмших үйл ажиллагаанд багш, эцэг эх, олон нийт, иргэд, сайн дурынхныг оролцохыг уриалах, урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой ажиллана.

1.2. Дээрх зорилгоор нэгдсэн хүсэл эрмэлзэлтэй бага, дунд, ахлах ангийн сурагчид сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж бүлгийн ахлагчаа тодруулан тухайн сургуулийн эрх бүхий удирдах албан тушаалтан баталгаажуулан томилсон, Ерөнхий боловсролын сургууль болон хүүхдийн зуслан дээр байгуулсан бүлгэмийг “Өсвөрийн аврагч бүлэг” гэнэ.

1.3. “Өсвөрийн аврагч бүлэг” нь болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, осол, гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг сурагчдад эзэмшүүлэх замаар аюулгүй амьдрах ухаан хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг арга хэлбэр юм.

1.4. “Өсвөрийн аврагч бүлэг”-ийн үйл ажиллагааг Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, зохион байгуулагч нар дэмжлэг үзүүлж сурагчдыг сургалтанд хамруулах, мэргэжлийн заавар зөвлөмжийг олгон хамтран ажиллах, нэгдсэн удирдлагаар ханган, чиглүүлж ажиллана.

## Хоёр. Бүлгийн гишүүнчлэл, гишүүдийн үүрэг

2.1. “Өсвөрийн аврагч бүлэг” нь гишүүд, идэвхтэн гэсэн гишүүнчлэлтэй байх ба ерөнхий боловсролын бага, дунд, ахлах ангийн насны ангиллаар сургуулийн сурагчдын тооноос хамаарч нэг сургуульд хэд хэдэн бүлэг байгуулж болно.

2.2. Бүлгийн гишүүн сурагчид өөрсдөө бүлгийн ахлагч, салааны захирагч, өсвөрийн аврагч-гал сөнөөгч, өсвөрийн сувилагч, өсвөрийн холбоочин, өсвөрийн санхүүч, сурталчилгааны ажилтан гэх мэт ажил үүргийг хуваарилан томилгоожуулж үйл ажиллагааг зохион байгуулна. Эдгээр үүрэг хүлээх сурагчдыг бүлгийн нийт гишүүдийн хурлаар санал хураалт явуулж сонгон шалгаруулна.

2.3. Бүлгийн ахлагч: Бүлгийн өдөр тутмын үйл ажиллагааг сургуулийн нийгмийн ажилтан, зохион байгуулагчийн шууд удирдлаган дор зохион байгуулж, бусдад үлгэр дуурайл үзүүлэх бөгөөд заах аргын чадвар бүхий бага, дунд, ахлах ангийн сурагчдаас сонгон шалгаруулалтаар томилно.

2.4. Салааны захирагч: Бүлгийн гишүүдийн өдөр тутмын үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих, үйл ажиллагааг удирдах үүрэгтэй, бүлгийн ахлагчийн эзгүйд түүний орлогч болж бусдыг удирдан зохион байгуулж манлайлан ажиллах чадвар бүхий сурагчдаас сонгож томилно.

2.5. Өсвөрийн сувилагч: Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх дадал чадвар эзэмшсэн, бусдад энэ талын чиглэлээр хичээл заах чадвар бүхий сурагч байна.

2.6. Өсвөрийн холбоочин: Гамшгаас хамгаалах арга хэмжээний үед болон өдөр тутмын үйл ажиллагааны үед цаг үеийн холбогдолтой шуурхай мэдээ, мэдээлэл цуглуулах, бүлгийн гишүүдийг мэдээллээр хангах үүрэг бүхий сурагчдаас бүрдэх бүлгийн 2-3 гишүүн байна.

2.7. Өсвөрийн сурталчилгааны ажилтан: Сургууль, хамт олон, орон нутаг, иргэд олон нийтэд өөрийн бүлгийн үйл ажиллагааг сурталчлах, бүлгийн түүхийн товчооныг хөтлөх, бүлгийн мэдээллийн самбарыг хариуцах үүрэгтэй, бага, дунд, ахлах ангийн сурагчдаас сонгож томилно. Бүлгийн 3-5 гишүүн байна.

2.8. Өсвөрийн аврагч-гал сөнөөгч: Дээрх үүрэг гүйцэтгэх гишүүдээс бусад бүлгийн гишүүд байж, бүлгийн үндсэн үүргийг гүйцэтгэх гол хүч болно.

2.9. “Өсвөрийн аврагч бүлэг”-ийн гишүүд улирал, эсвэл хагас жилээр ажил үүргийн хуваариа гишүүд хоорондоо сольж шинэ зүйлд суралцаж, өөрсдийн авъяас чадвараа хөгжүүлэн, удирдан зохион байгуулах, багийн идэвхтэй гишүүн байх зэргээр өөрсдийн ур чадвараа байнга хөгжүүлэхийг чухалчилна.

Мөн үйл ажиллагаагаа “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг гүнзгийрүүлж судлах, үе тэнгийн найз нартаа мэдсэн сурснаа түгээн дэлгэрүүлэх чин эрмэлзлэлтэй байна.

## Гурав. Өсвөрийн аврагч бүлгийн үнэт зүйл

3.1. “Өсвөрийн аврагч бүлэг”-ийн гишүүд бусад сурагчдаас ялгарахаар улбар шар өнгийн бүч, зангиа, малгай, ялгэх тэмдэг зэргийг хэрэглэнэ. Энэ нь бусдад бүлгээ сурталчлах сайн талтай, олон нийт илүү хүлээж авах чухал ач холбогдолтой. Эдгээрийг байнга хэрэглэх нь гишүүд өөрсдөөрөө болон хийж байгаа ажлаараа, зорилгоороо бахархах сэтгэгдлийг сурагчдад төрүүлнэ.

3.2. Өсвөрийн аврагч бүлгийн үндсэн БЭЛГЭДЭЛ нь дараах утга санааг илэрхийлсэн таних тэмдэг байна.

СОЁМБО нь тусгаар тогтносон, бүрэн эрхт, эртний түүх, соёл, төр ёсны арвин баялаг уламжлал бүхий эх оронд МОНГОЛ хүнийг илэрхийлнэ.

ТАВАН ХОШУУ нь андгай өргөсөн Өсвөрийн аврагчийг илэрхийлнэ.

ГУРВАЛЖИН нь иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдэг, гурван өнгийн гар нь эв нэгдэл, хамтын ажиллагааг илэрхийлнэ.

НОМ нь гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсрол гэсэн утга санааг илэрхийлнэ.

Эмжсэн ЧИДУН ЖИМСНИЙ МӨЧИР нь ялалт, амжилтыг бэлгэдэх ба мөнхөд оршихуйн утга санааг илэрхийлнэ.

ӨНГӨ нь гал, ус, эх дэлхийг бэлгэднэ.



Өсвөрийн аврагч бүлэг нь өөрийн НЭР, УРИА, АНДГАЙ-тай байна.

3.3. Өсвөрийн аврагч бүлгийн АНДГАЙ нь: “Монгол Улсын иргэн би Өсвөрийн аврагч бүлгийн гишүүний хувьд аюулгүй амьдрах арга ухаанд суралцаж, бусдад зөв үлгэр дуурайлал болж эх дэлхий, эх орноо чин сэтгэлээсээ хайрлан хамгаалхаа АНДГАЙЛЖ байна”.

## Дөрөв. Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаа

4.1. “Өсвөрийн аврагч бүлэг”-ээс зохион байгуулж буй аливаа арга хэмжээ нь сурагчид, тэдний гэр бүл, олон нийтийг болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, осол, гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг авран хамгаалах талаар мэдээлэл өгөх, боловсрол олгоход чиглэгдэхийн зэрэгцээ, “Өсвөрийн аврагч” тэмцээнд сургуулиа төлөөлөн оролцох, гишүүд багаар ажиллаж сурах, хамтран шийдвэр гаргах, илтгэл бэлтгэх, илтгэх зэрэг олж авсан мэдлэг, ур чадвараа бусадтай хуваалцах, эзэмшүүлэх зэрэг ур чадваруудыг сонирхолтой, үр дүнтэй арга хэлбэрээр эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

4.2. “Өсвөрийн аврагч бүлэг”-ийн дотоод үйл ажиллагаа гэдэг нь хөтөлбөрийн дагуу сургалт явуулах, тогтмол хурал зохион байгуулах, ажлаа жил, улирлаар төлөвлөх, төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бэлтгэлээ хангах, түүнийг хэрэгжүүлэх болон гишүүдээ сургах, бэлэн байдлыг хангуулах, чадавхжуулах зэрэг үйл ажиллагаа юм. Хурлыг бүлгийн удирдагч, ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, зохион байгуулагч удирдах бөгөөд тэрээр хурлын товыг зарлах эрхтэй.

4.3. Удирдлагын эзгүйд Бүлгийн ахлагч хурлыг удирдаж, дотоод үйл ажиллагааг зохион байгуулна.

4.4. Бүлгийн хурал, цуглааны үндсэн үүрэг нь:

4.4.1. Гишүүдийн зүгээс бүлэгтээ цаашид идэвхтэй ажиллах хүсэл эрмэлзлэлийг нь төрүүлэх. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд гишүүд андгайгаа унших, бүлгийнхээ уриаг хэлэх, бүлгийнхээ нэрэмжит дуу зохиож дуулах, ололт амжилтаа санан дурсах гэх мэт сэдэл төрүүлэх зүйлсийг хийнэ.

4.4.2. Өмнө болсон үйл ажиллагаагаа дүгнэж, цаашдын ажлаа төлөвлөх. Тодорхой зорилтот даалгавар авсан гишүүд үйл ажиллагааныхаа талаар тайлагнана. Мөн бэрхшээлтэй зүйлс, тулгамдаж байгаа асуудлыг ярьж, цаашид ямар ажил хийх саналтай байгаа талаар танилцуулж, хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргана. Ингэхдээ хариуцах эзэн, хугацаа зэргийг тодорхой зааж өгнө.

4.4.3. Орон нутгийнхаа нөхцөл байдлын талаар шинэ мэдлэг эзэмших, бусаддаа зааж сургах: Орон нутгийнхаа нөхцөл байдлын талаар шинэ зүйлсийг мэдэж авахын тулд холбогдох Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, Олон улсын байгууллагын дарга, захирал, мэргэжилтэн, багш, ахмад сурган хүмүүжүүлэгч, иргэдээр танхимын болон дадлага сургалт авах, яриа хийлгэх, богино хэмжээний сургамжит кино, шторк, сэрэмжлүүлэг, гарын авлага, тараах материалаар хангуулах, гишүүд хоорондоо өөрсдийн олж авсан шинэ мэдээллийн талаар ярилцаж бүгдээрээ хэлэлцэнэ.

4.4.4. Гишүүдийнхээ авъяасыг нээх, хамтдаа ажиллах, эв нэгдэлд суралцах, бие бялдраа хөгжүүлэх. Шинээр дуу, шүлэг сурах, авран хамгаалах үйл ажиллагаатай холбоотой сурагчдад тохирсон тоглоом тоглох, жүжигчилсэн тоглолт хийх, “Өсвөрийн

аврагч тэмцээн"-ийг сургуулийн орчинд зохион байгуулах, сум, дүүрэг, аймаг, хот, бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэж оролцох зэрэг үйл ажиллагаа явуулна.

4.5. Өсвөрийн аврагч бүлэг нь өөрийн сургууль болон зуслангийн оршин байгаа газрын мэргэжлийн байгууллага болох Онцгой байдлын газар, хэлтэс, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай нягт хамтран ажиллаж, заавар зөвлөмжөөр хангагдана.

Тав. "Өсвөрийн аврагч бүлэг"-ийн нөөц, санхүү

5.1. "Өсвөрийн аврагч бүлэг"-ийн гол нөөц бол сурагчид, гишүүд юм. Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаа явуулж байгаа өрөө танхим нь бусдад нээлттэй байна.

5.2. "Өсвөрийн аврагч бүлэг"-ийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарч янз бүрийн техник хэрэгсэл, материалууд зайлшгүй хэрэгтэй байна. Тухайлбал:

- эмийн сан
- анхан шатны тусламжийн багц
- хүний биеийн макет
- хүрз, хувин, бусад багажууд
- гарын авлага, танилцуулга
- орон нутгийн газрын зураг
- компьютер, мэдээллийн хэрэгсэл, аппарат, зурагт, VCD, CD тоглуулагч (сургуулийнхыг ашиглаж болно)
- мэдээллийн самбар
- бичгийн хэрэгсэл гэх мэт.

5.3. "Өсвөрийн аврагч бүлэг" байнгын үйл ажиллагаа явуулахад дээрх нөөцөөс гадна бичиг хэргийн, Өсвөрийн аврагч тэмцээний гэх мэт тодорхой зардлууд гардаг тул өөрийн гэсэн санхүүгийн нөөцтэй байх ба түүнийг ерөнхий боловсролын сургуулийн Гамшгаас урьдчилан сэргийлэх болон Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас тодорхой хэмжээгээр зарцуулах замаар шийдэж болно.

5.4. Бүлгийн үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх орон нутгийн хуулийн этгээд болон олон улсын байгууллага, сайн дурын хандив тусламжаар ивээн тэтгүүлж болно.

5.5. Бүлгийн гишүүдийн үйл ажиллагаанаас (аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээлэл бүхий бяцхан ном, гарын авлагыг бэлтгэж иргэд олон нийтэд түгээх, урлагийн болон үзүүлэх тоглолт хийх ... гэх мэт) орлого олж болно.

5.6. Өсвөрийн аврагч бүлгийн санхүүгийн нөөц, үйл ажиллагааны зардлын тооцоог бүлгийн хурлаар гишүүдэд танилцуулна.

5.7. Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, дэмжиж ажилласан талаар орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс улирал, жилийн ажлын тайландаа тусгана.

#### Зургаа. “Өсвөрийн аврагч бүлэг”-ийн гишүүдийн шинэчлэлт, судалгаа

6.1. “Өсвөрийн аврагч бүлэг”-ийн гишүүдийн шинэчлэлт, судалгааг жил бүрийн 09 дүгээр сард багтаан гаргаж тухайн орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэст ерөнхий боловсролын сургуулийн захирлаар уламжлан албан бичгээр хүргүүлж байна.

#### Долоо. “Өсвөрийн аврагч” уралдааны удирдлага зохион байгуулалт

7.1. Ерөнхий боловсролын сургууль дээр “Өсвөрийн аврагч” бүлгийг удирдагч багш нь уралдаанд чиглүүлэн арга зүйгээр ханган ажиллана.

7.2. Орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл урлагийн газар бүлгийн удирдагч багш, бүлгийн гишүүдийг чадвахжуулах, арга зүйн удирдлагаар хангах үүрэг хүлээнэ.

7.3. Орон нутгийн Онцгой байдлын газар нь бүлгийн удирдагч багш, бүлгийн гишүүдэд зориулсан дадлага сургуулилалтыг жил бүр зохион байгуулна.

7.4. Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгийн онцгой байдлын газар нь орон нутаг, бүсийн шилдгийг тодруулах “Өсвөрийн аврагч” тэмцээнийг 2 жилд нэг удаа, улсын аварга шалгаруулах тэмцээнийг 3 жилд нэг удаа холбогдох төр, төрийн бус, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН СПОРТЫН ЯАМ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР